

## Цахилгаан дамжуулах агаарын шугам дээр суурилуулах богино залгааны гэмтэл заагч төхөөрөмжид тавигдах техникийн шаардлага

Хянаж буй шугам дээр богино залгаа болох үед гэмтэлтэй фаз дээр гүйдэл огцом ихсэх үед мөн түүнчлэн нэг фазын богино залгаа, фаз хоорондын богино залгаа, тогтворгүй болон тогтвортой богино залгааны гүйдлийг мэдэрч ажилладаг байх үед тухайн фаз дээрх тэг дарааллын гүйдэл огцом нэмэгдэх үед индикатор мэдэрч дохиолдог байна. (6-35 кВ-ын ЦДАШ-д ашиглагдана.)

- Бүх төрлийн индикаторууд нь өөрийн ажиллагааг хянах функцтэй (self test) байх ёстой. Батарейн дуусах хугацаа болон өөрийн гэмтэлтэй байгааг илрүүлсэн үед дохиолдог байх ёстой.
- Тавил тохируулах боломжтой байна. (Di/Dt: 6-60A 8-аас багагүй тавил)
- Бүх индикаторын их бие нь нарны хэт ягаан туяаны үйлчлэлд тэсвэртэй материалаар хийгдсэн байна. Орой хэсэгт борооны ус тогтоохооргүй байна.
- Индикаторууд нь шугамын утсанд бэхлэх зориулалтай хавчаартай байх ба хавчаарын гадаргуу нь шугамын утас дээр халтирч гулгахгүй утасны чичиргээнд гадаргууг нь гэмтээхээргүй материалаар бүрэгдсэн байх ёстой.
- Агаарын шугамын утсанд бэхлэх индикаторуудыг шугамын хүчдэлийг таслахгүйгээр тусгаарлах штангний тусламжтай бэхэлж суурилуулах боломжтой байна. Тусгаарлах штанг 2 ш хамт нийлүүлнэ.
- Батарей дуусах, тогтвортой, тогтворгүй богино залгааны үед өөр өөр өнгийн гэрлээр дохио өгдөг байна. (шар, улаан, ногоон)
- Батарей (Литиум) нь 10-аас багагүй жилийн ажиллах хугацаатай байна.

<b>Шугамын гэмтэл мэдрэх төхөөрөмж</b>	
Ачааллын гүйдэл	0-630А
Ажиллах хүчдэлийн хязгаар	6-35 кВ
Тусгаарлагын даац	125 кВ-аас багагүй
Хамгийн их хүчдэл	60кВ /хүртэл хүчдэлийн хязгаарт ажиллах боломжтой байх/
Гүйдлийн мэдрүүрийн нарийвчлал	±1%
Давтамж	50Гц
Богино залгааны гүйдлийн тэсвэрлэх	2 секундын турш 20 кА-аас багагүй
Хавчаарын хэмжээ	35-120 мм <sup>2</sup> хөндлөн огтлолтой шугаманд суурилуулах
Жин (мэдрүүр)	3 кг-аас ихгүй байна.
Ажиллагааны төрөл	<ul style="list-style-type: none"> <li>• 1 фаз газартай богино залгаа,</li> <li>• Фаз хоорондын богино залгаа,</li> <li>• Тогтворгүй болон тогтвортой богино залгааны гүйдлийг мэдэрч ажилладаг байх</li> </ul>
Харагдах өнцөг	360 °
Гэрлэн диод	Super bright LED, 12000 mcd-багагүй байна.
Харагдах байдал	Өдрийн цагт 200м,

	шөнийн цагт 500м-ээс багагүй зайд нүдэнд үзэгдэхүйц байх
Ажиллах нөөц	2000-аас багагүй удаа
Төхөөрөмжийн гадна гэр хамгаалалтын зэрэг	IP54
Шугам хүчдэлтэй үед бага гүйдлээр өөрийгөө цэнэглэдэг горимтой байна.	
Механик цохилт, чичиргээнд тэсвэртэй байх	
Төхөөрөмжийн заалтыг буцаах арга	Автомат, хугацааны барилттай (0-48 сонголттой байх), гараар заалтыг тэглэх боломжтой байх
<b>Бүх тоноглолуудын ажиллах орчны нөхцөл</b>	
Хэвийн ажиллах температур	-40-өөс +65° С
Хадгалалтын температур	-40-өөс +65° С
Далайн түвшинээс дээш	2000 м
Чийгшил	5%-95%